

## МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧААС ЗОХИОН БАЙГУУЛАХ ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2026.6.24

Улаанбаатар хот

Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг олон нийтэд ил тод, хүртээмжтэй хүргэх зорилгоор байгууллагын вэб хуудас болон Facebook, YouTube, X (Twitter), LinkedIn, Instagram зэрэг цахим сувгаар нийт 79 төрлийн мэдээлэл, контент бэлтгэн түгээж, давхардсан тоогоор 1,442,523 иргэнд хүргэв. Цахим сувгуудаар ирүүлсэн иргэдийн санал, хүсэлт, асуултад шуурхай хариу өгч, нийт 1,155 иргэнд мэдээлэл, зөвлөгөө хүргэн ажиллав. Мөн 2026 оны 3 сарын 26 Дархан-Уул,

- 2026 оны 4 сарын 5 Төв аймаг,
- 2026 оны 4 сарын 9 Булган,
- 2026 оны 4 сарын 12 Орхон,
- 2026 оны 4 сарын 23-26 Боловсролын Шинэчлэл – 2026,
- 2026.5.1 Баянхонгор,
- 2026.5.4 Дундговь,
- 2026.5.6 Нийслэлийн ерөнхий боловсролын 105-р сургууль,
- 2026.5.7 Өвөрхангай,
- 2026.5.11-13 “Нээлттэй хаалганы өдөрлөг”,
- 2026.5.16 Сонгинохайрхан Боловсрол 2026,
- 2026.5.22 Оросын 3 дугаар сургууль,
- 2025.5.27 Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК зэрэг байгууллагуудад сургалтын зээл, тэтгэлэг болон байгууллагын үйлчилгээний талаарх мэдээлэл, зөвлөгөө хүргэв.





Дээрх арга хэмжээний хүрээнд 4,000 гаруй брошур тарааж, 10,000 гаруй иргэнд танхим болон газар дээрх зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ үзүүлэн ажиллав.

Түүнчлэн төрийн болон боловсролын байгууллагуудад сургалтын зээл, тэтгэлгийн талаарх мэдээллийг тогтмол хүргэж, иргэдээс ирүүлсэн асуулт, хүсэлтийн давтамжид үндэслэн зорилтот контент боловсруулан түгээнээр мэдээллийн хүртээмж, хүртээлтийг нэмэгдүүлэн ажиллав.

Иргэдийн санал, хүсэлтийг сонсох нээлттэй уулзалтыг тогтмол зохион байгуулж Зээлийн сангийн Ажлын албаны дарга иргэдтэй биечлэн уулзаж, зээл, тэтгэлэг, эргэн төлөлттэй холбоотой тулгамдсан асуудал, санал хүсэлтийг сонсон, харилцан санал солилцон ажиллаа.

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САН